



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 17 онд

Дугаар A/370

Зуунмод

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Номт 1-р баг, Жаргалан хотхон, Зохиолчдын гудамж 118 тоотод оффис, конторын зориулалттай 1335м² газар эзэмшигч Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Төв аймгийн зөвлөл /1013122/-ийн газар эзэмших эрхийн хугацааг 15 жилээр сунгасугай.

2. Газар эзэмшигч Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Төв аймгийн зөвлөлийн дарга Н.Оюунтунгалагт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1 Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2 Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3 Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4 Эзэмшил газрын төлөв байдлын чанаарын хянан баталгааг хийлгэх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1 Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2 Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Зуунмод сумын Засаг даргын 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 205 дугаар захирамж болон БХТН-ийн Төв аймгийн зөвлөлийн 182700152 дугаар газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

010 01154